

БАНКНЫ САЛБАРЫН 95 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулиудын оюутнуудын дунд Монгол улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойд зориулан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах гэж байна.

НЭГ. ЗОРИЛГО

Эдийн засаг, статистик болон санхүүгийн чиглэлээр сурч буй оюутан, судлаачдын судалгаа хийх чадварыг дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлэх, олон нийтийн эдийн засгийн талаарх ойлголтыг дээшлүүлэх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. СЭДВИЙН ЧИГЛЭЛ

Эрдэм шинжилгээний бүтээлийн сэдвийн чиглэл:

- Төв банкны зорилт, түүнийг хангах мөнгөний бодлогын оновчтой хэлбэр,
- Төв банкны хараат бус байдал ба мөнгөний бодлогын орон зай
- Иргэдийн санхүүгийн мэдлэг ба эдийн засгийн тогтвортой байдал
- Төсвийн болон мөнгөний бодлогын уялдаа
- Мөнгөний бодлогын макро эдийн засагт үзүүлэх нөлөөлөл
- Төсвийн бодлогын макро эдийн засагт үзүүлэх нөлөөлөл
- Мөнгөний захын хөгжлийг түргэсгэх боломж, тулгамдаж буй асуудал,
- Санхүүгийн захын хөгжлийн асуудлууд
- Макро зохистой бодлого, түүний арга хэрэгслүүд, эдийн засагт үзүүлэх нөлөө
- Үнийн эсвэл ханшийн тогтвортой байдлыг эрхэмлэсэн мөнгөний бодлого: Хэрэгжүүлэх суурь нөхцөл, эдийн засагт үзүүлэх нөлөө
- Үнийн тогтвортой байдал, макро эдийн засгийн тогтвортой байдлын уялдаа
- Валютын ханшид нөлөөлөгч хүчин зүйлс
- Валютын ханш, инфляцийн динамикийг үйл хөдлөлийн санхүү, эдийн засгийн онол (behavioural finance and economics)-оор тайлбарлах нь
- Эдийн засгийн бодлогын тодорхой бус байдлын индексийн тооцоо
- Хэрэглээний зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөө
- Банкны ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлс
- Зээлийн бүтэц, түүний эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө
- Санхүүгийн тогтвортой байдлын түрүүлэгч индикаторууд
- Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, түүний санхүүгийн салбар, эдийн засгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөө
- Банк, санхүүгийн салбарын бусад сэдвүүд байж болно.

ГУРАВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Эрдэм шинжилгээний хурлыг 2 үе шаттай зохион байгуулна. Оролцогч оюутан заавал удирдагч багштай байх шаардлагатай.

Бичгээр ирүүлэх судалгааны ажилд тавигдах шаардлага:

1.1 Судалгааны ажлын ерөнхий шаардлага:

- Онол, арга зүйн үндэслэлтэй
- Шинэлэг, оновчтой санал, санаачлагыг дэвшүүлсэн
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан
- Эконометрик, статистикийн арга хэрэгслүүдийг ашигласан
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, үр дүнд хүрсэн байх
- Урьд өмнө нь илтгээгүй, бусдын ажлыг шууд хуулбарлаагүй байх
- Судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдсан байх

1.2 Бичвэрт тавигдах шаардлага:

- Нүүр хуудсанд судлаач өөрийн нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, сургууль, курс, мэргэжил, судалгааны ажлын нэр, удирдагч багшийн нэрийг бичих;
- Судалгааны ажлаа бичгийн А4 цаасан дээр бичих бөгөөд дээд тал нь 15 хуудсанд багтсан байх;
- Илтгэл нь гарчиг, хураангуй, түлхүүр үг, удиртгал, судалгааны хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдсэн байх
- Бичгийн стандарт: Үсгийн фонд – Times New Roman, үсгийн хэмжээ- 12, мөр хоорондын зай – 1,5, margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм;

Шалгарсан бүтээлүүдийг Монголбанк, МУИС-ийн Эрдэнэт сургууль, Хаан банк, Голомт банк, Капитрон банкны албан ёсны вебсайт болон бусад социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.

ДӨРӨВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Эрдэм шинжилгээний хурлын эхний шатанд судалгааны ажлыг файл хэлбэрээр хүлээн авч шалгарсан илтгэлийг дараагийн шатанд хэлэлцүүлнэ.

Илтгэл хүлээн авах: Нэгдүгээр шатанд судалгааны ажлыг **2019 оны 4 дүгээр сарын 17-ныг** дуустал МУИС-ийн Эрдэнэт сургууль, Санхүү-Эдийн засгийн тэнхим /304 тоот/ эсвэл Oyunaad_8@yahoo.com хаягаар файл(pdf) хэлбэрээр хүлээн авна. Нэгдүгээр шатанд ирсэн илтгэлүүдийг комисс урьдчилан шүүж, дараагийн шатанд хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

Илтгэл хэлэлцүүлэх: Эхний шатанд шалгарсан илтгэлүүдийг **2019 оны 4 дүгээр сарын 22-нд** цахим хаягаар хариу мэдэгдэнэ. 2019 оны 4 дүгээр сарын 25-ны дотор шалгарсан илтгэгч нар илтгэлийн танилцуулгыг (powerpoint болон бусад хэлбэрээр) Oyunaad_8@yahoo.com хаягаар ирүүлсэн байна. Хоёр дахь шатны шалгаруулалт **2019 оны 4 дүгээр сарын 26-нд** МУИС-ийн Эрдэнэт сургуулийн **305 тоот танхимд 10⁰⁰ цагт** эхлэх болно.

ТАВ. ШАГНАЛЫН САН

- 1-р байр - Өргөмжлөл, 500.000 төгрөг
- 2-р байр - Өргөмжлөл, 300.000 төгрөг
- 3-р байр - Өргөмжлөл, 200.000 төгрөг

Хуралтай холбоотой мэдээллийг: Утас: 8810-0308, 9935-3500, И-мэйл: Oyunaad_8@yahoo.com хаягаар лавлана уу.

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД:

